

НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН УЛСЫН БОДЛОГО

ын чухал бүрэлдэхүүн хэсэг нь биеийн тамир, спорт, аялал жуулчлалыг хөгжүүлэх явдал юм. Биеийн тамир, спортын салбар дахь БУИС-ийн бодлогын гол зорилго бол оюутан залуучуудыг сурган хүмүүжүүлэх, эрүүл ахуйг төлөвшүүлэх бөгөөд БУИС-ийн тамирчдыг төрөл бүрийн тэмцээнд амжилттай оролцохыг дэмжих. Буриад тамирчид янз бүрийн ангиллын тэмцээнд амжилттай оролцож байсан бат бэх суурь дээр 1960 онд Биеийн тамир, спорт, аялал жуулчлалын факультетийг байгуулсан нь шинжлэх ухаан, сургалтын үйл ажиллагааг өрнүүлэн, спорт аялал жуулчлалын салбарт амжилт төгөлдөр ажилласаар байна. 1995 оноос факультет дээр 13.00.04 дугаартай «Биеийн хүмүүжил, спортын дасгал, эрүүлжүүлэх болон дасан зохицох биеийн тамирын онол заах аргазүй» мэргэжлээр аспирантур нээгдэж ажилласаар байна. 1997 онд сурган хүмүүжүүлэх ухааны дэд докторын зэрэг хамгаалах зөвлөл нээгдсэн байна. 2012 оноос биеийн тамирын чиглэлээр магистрын сургалт хийж эхэлсэн юм.



**БУРИАД
УЛСЫН
ИХ СУРГУУЛИЙН**



**БИЕИЙН ТАМИР
СПОРТ, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН ФАКУЛЬТЕТ**



элсэлтийн комисс:
670000, Улаан-Үд хот, Смолины гудамж, 24а
Утас: +7(3012)21-74-26
udp@bsu.ru

Site: www.bsu.ru

E-mail: univer@bsu.ru



ТЭНХЭМҮҮД:

Биеийн тамирын онолын тэнхэм

Спортын чиглэлийн тэнхэм

Биеийн хүмүүжлийн тэнхэм

МӨН:

Спорт дахь шинэчлэлт технологийн лаборатори;
«АЯН» аялал жуулчлалын төв



ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТ БОЛОН СПОРТ ЭРҮҮЛЖҮҮЛЭХ ЖУУЛЧЛАЛ

Мэргэжил: Чийрэгжүүлэлт болон спорт эрүүлжүүлэх жуулчлал

Мэргэшил: Бакалавр

Сургалтын хэлбэр: өдрөөр сурах – 4 жил, эчнээ сурах – 5 жил

Элсэх шалгалт: Биеийн тамир, орос хэл, биологи

Ажил эрхэлж болох салбарууд: Спорт эрүүлжүүлэх жуулчлал; биеийн тамирын чийрэгжүүлэлт, нөхөн сэргээлт; биеийн тамир, спорт, аялал жуулчлалын аргаар хүн амыг эрүүлжүүлэх үйл ажиллагаа; аялал жуулчлал, чөлөөт цагийн амралт, чийрэгжүүлэлтийн аж үйлдвэр; аялал жуулчлал чийрэгжүүлэлтийн байгууллага болон системүүд; аршаан сувиллын байгууллага; биеийн тамир спорт, чийрэгжүүлэлт аялал жуулчлалын салбар дахь бусад төрлийн үйлчилгээ.

БИЕИЙН ТАМИР

Мэргэшил: бакалавр

Мэргэжил: Спортын дасгал сургалт

Сургалтын хэлбэр: өдрөөр сурах – 4 жил, эчнээ сурах – 5 жил

Шалгалт: Биеийн тамир, орос хэл, биологи

Мэргэшил: Магистр

Мэргэжил: Биеийн тамирын онол болон биеийн хүмүүжлийн технологи

Сургалтын хэлбэр: өдрөөр сурах – 2 жил, эчнээ сурах – 2,5 жил

Шалгалт: Биеийн тамир болон спортын онол

Ажил эрхэлж болох салбарууд:

Биеийн тамир, спорт, хөдөлгөөнт чийрэгжүүлэлт болон спорт, биеийн тамирын аргаар хүн амыг өвчнөөс сэргийлж эрүүлжүүлэх зэрэг салбар



МАТЕРИАЛ ТЕХНИКИЙН ХАНГАМЖ

Аэробик, спортын бүжгийн 2 заал,

Спорт тоглоомын 2 заал,

Бөхийн заал,

Боксын заал,

Хөл бөмбөгийн хиймэл ширэгтэй цэнгэлдэх хүрээлэн,

Сур харвах талбар,

Гимнастикий танхим,

Теннисийн талбай,

Байгал нуур, Шаргал нуурын орчим хоёр спортын эрүүлжүүлэх баазтай

